



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 02 өдөр

Дугаар А/330

Алтай хот


Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн "Аймгийн 2023 оны төсөв батлах тухай" 64 дүгээр тогтоол, мөн 2023 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн "Аймгийн 2023 оны төсвийг тодотгон батлах тухай" 14 дүгээр тогтоол, Үнэлгээний хорооны 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 43 дугаар зөвлөмжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэх ГААОНӨГ/2023/2014 дугаартай Хөхморьт сумын бага оврын цэвэрлэх байгууламжийн угсралт, суурилуулалт, зүгшрүүлэлт, тохируулгын ажлыг "Хонгор буурал" ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлэх эрхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Д.Алтанзагас)-т олгосугай.

2.Гүйцэтгэлчийн санал болгосон ажил гүйцэтгэх хугацаа, ажлын тоо хэмжээ, техникийн тодорхойлолт зэргийг үндэслэн холбогдох хууль, журмын дагуу эрх үүрэг захиалагчийн хяналт, хариуцлагыг гэрээнд тодорхой тусгаж, хэрэгжилтийг тайлагнаж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Д.Алтанзагас)-т үүрэг болгосугай.

3.Ажлын гүйцэтгэл, чанар, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ), Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг)-т тус тус даалгасугай.

ОРЛОГЧ  ГЧИНБАТ

C:/ My Documents A-4 doc

0020102109

